

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Чагнаагийн Мажиг	Дугаар	L066
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Хөлөнбуйр сум
Төрсөн газар	Өвөр Монгол	Төрсөн он	1924
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Баргын хийд	Сүм хийдийн дугаар	ДОХБ 002
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Баргын хийд

-Хөлөнбуйр сумд байсан хүрээ хийдийн талаар та юу мэдэх вэ?

Би барга хүн. 1945 онд энд / Монголд/ орж ирсэн. Манайхан их олуулаа орж ирсэн. Тэгэхдээ өөрсдөө хийдтэйгээ орж ирсэн. Тэр хийд маань Гандантай нэгдсэн. Тэр хийдийн нэрийг би сайн мэдэхгүй байна. Одоо тэр хийдийн зүйлсээс төв Ганданд Баргын Махгал гээд бурхан байгаа биз дээ.

Хийдийн сахиус юу байсан бэ?

Тэр Махгал чинь байсан юм. Би хотод очихоороо адис авч мөргөдөг юм.

-Хэр олон ламтай хийд байсан бэ?

10, 20-иод лам байсан. Дээд томчуулыг нь Гандан татаж аваад бага жижгүүд нь хар болж үлдсэн.

-Хэдэн дугантай байсан бэ?

Ердөө ганц л байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Өвөр Монголоос орж ирсний дараа хэдэн жил эндээ хурсан бэ?

За нэг 2, 3 жил л болсон байх даа.

-Хийдийг удирдаж байсан лам нар нь хэн хэн байв?

Ширээт лам гэж байв.Өвгөн лам. Ямар Равжаа гэвш билээ нэг тийм хүн байсан. Хамгийн том лам нь. Бас Жимба гэж байв. Миний хамаатан байсан юм. Жигмэд гэж байв. Тэд одоо бүр байхгүй.

-Гэсгүй лам нь, унзад нь хэн хэн байсан бол?

Гэсгүй нь Жигмэд байсан. Унзад нь Жимбэ гэж манай хамаатны тэр хүн байсан юм.

-Хийдэд ямар ямар хурал хурдаг байсан тухай та мэдэх үү?

Зундаа Майдар эргэдэг байсан. Майдарт манайхан их ирдэг байсан.

-Хайлантай байсан үү?

Байсан. Тэр чинь хэд хоног билээ? Ламын дэргэд энгийн хар хүн эд нар байхгүй тийм байсан.

-Ер нь цагийн хуралтай байсан уу, өдөр тутмын хуралтай байсан уу?

Өдөр тутмын байсан. Өглөө нэг хурал хурдаг байсан. Өглөө нь дун татаад лам нар цугладаг.

-Харин цамгүй байсан байх аа?

Цам гардаггүй байсан. Майдар гээд баахан юм боловшиг. Харин Майдарт ойр холын энэ Сүхбаатар аймаг гээд хаа хаанаас их олон хүн ирнэ. Тэр үед чинь лам байдаггүй байсан.

-Яг хэдэн онд Гандантай нэгдсэн юм бэ?

Манай хурал анх 1945 онд аймгаас урагш байсан. Булганы туг дээр бас гэртэй байсан. 1946, 1947 оны үед энд гээгт Содномдаржаа гэдэг хүн дуган барьж өгсөн. Тэгээд 2,3 жил хураад Гандантай нийлсэн.

-Тэр Жимба лам хэдэн онд нас барсан бэ?

Одоогоос 7,8 жилийн өмнө нас барсан. Жимба лам гэж ээжтэйгээ хоёулаа амьдарч байсан.